



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/496

Арвайхээр

**Г Бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар
шилжүүлсэн хугацааг сунгах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах” тухай 159 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 30 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасугай.

2.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Амны хаалтаа зүүцгээе” аяныг эрчимжүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумын Засаг дарга нарт, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011101095